210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000.00	3,450.00
2105	Нормативт зардал	9,441.13	21,046.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,441.13	20,706.30
210502	Хоол, хүнс	-	340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000.00	3,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000.00	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	-	3,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,344.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		1,344.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	463.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		463.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,045.61	14,984.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,045.61	10,995.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000.00	3,988.92
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	35,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		10,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		25,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,616.50	125,884.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,616.50	125,884.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,201.76	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	-
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,400.00	9,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,014.74	115,184.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,700.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга А.Асет танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн болон сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад шалгалт хийгдээгүй байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 4,440.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 44.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 31.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 56.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 169.1 сая төгрөг болж, 112.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	56.5	169.1	112.6	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	56.5	169.1	112.6	

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 169.1 сая төгрөг болж 112.6 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 169.1 сая төгрөгийн 10.4 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 54.2 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 104.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 0.4 сая төгрөг нь Байгаль орчныг хамгаалах сангийн төрийн сан дахь дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 247.6 сая, эцсийн үлдэгдэл 253.9 сая төгрөг болж, 6.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.1	3.1	
Төлбөртэй үйлчилгээний авлага		40.8	40.8

Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	1.5	16.5	15.0
Зээлийн авлага	243.0	193.4	-49.6
Дүн	247.6	253.9	6.3

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 76.2 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 23.8 хувийг төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл тайлант онд зээлийн эргэн төлөлтийн хэмжээгээр буурсан байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага 40.8 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах Ковид-19 цар тахлын улаан бүсд ажилласан ажилчдын урамшуулал болон бараа үйлчилгээний зардлын авлага байна.

Бусад авлагын үлдэгдэл 15.0 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн цэцэрлэгийн авлага бөгөөд аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг “Чарж” ХХК-ний дансанд хөрөнгө нийлүүлэхээр шилжүүлж, шинээр авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Төсөвт байгууллагаас Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 3.1 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон авлага, 1.5 сая төгрөгийн бусад байгууллагаас авах авлагатай гарсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 284.1 сая, эцсийн үлдэгдэл 332.7 сая төгрөг болж, 48.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	45.0	57.1	12.1
Хангамжийн материал	238.8	268.5	29.7
Дүн	284.1	332.7	48.6

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 332.7 сая төгрөг болж 48.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 408.7 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 46.6 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 368.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 0.2 сая төгрөгийн материалыг шилжүүлж, 37.6 сая төгрөгийн материалыг акталсантай холбоотой байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 11.2 сая төгрөг нь Засаг даргын тамгын газрын, 1.3 сая төгрөг нь ИТХ-ын, 107.6 сая төгрөг нь Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн, 28.6 сая төгрөг нь Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн, 100.7 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 57.0 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 1.8 сая төгрөг нь Соёлын төвийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

1. Эрүүл мэндийн төв сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 35 дугаар тогтоолын дагуу 4.1 сая төгрөгийн эмийг акталж данс бүртгэлээс хассан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Сумын Засаг даргын шийдвэрээр Эргэлтийн эмийн сангийн хяналтын зөвлөл байгуулж ажиллуулаагүй, Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Эргэлтийн эмийн сангийн удирдах зөвлөл шийдвэрлэхээр заасныг зөрчиж Эргэлтийн эмийн сангийн эмийн санч орлого авсан эмийн худалдах үнийг өөрөө тогтоож орлого авдаг, үйл ажиллагаанаас бий болсон орлогыг юунд зарцуулж байгааг тогтоох боломжгүй, бүртгэл тооцоо хангалтгүй хийгдсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7641.9 сая, эцсийн үлдэгдэл 7584.0 сая төгрөг болж, 57.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7537.7	7479.8	-57.9
Биет бус хөрөнгө	104.1	104.1	0.0
Дүн	7641.9	7584.0	-57.9

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 34.0 сая, үнэ төлбөргүй хандиваар хүлээн авсан 244.0 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 84.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, акталсан байна. Дуусаагүй барилга дансанд хөрөнгө бүртгэгдээгүй байна. Тайланд үндсэн хөрөнгөнд нийтдээ 325.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 2021.3 сая төгрөгийн, бараа материалын дансанд 11.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 1977.7 сая төгрөгийн хөрөнгийг тоолж, 39.2 сая төгрөгийн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байна.

2. Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 114.7 сая төгрөгийн бараа материал, 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12.3 сая, эцсийн үлдэгдэл 40.1 сая төгрөг болж, 27.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0	17.1	17.1	42.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	6.6	6.6	16.4
Байгууллагад төлөх өглөг	12.3	16.4	3.4	41.0
Хувь хүмүүст төлөх өглөг				
Нийт дүн	12.3	40.1	27.1	100.0

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 42.6 хувийг ажилчидтай холбогдсон өглөг, 16.4 хувийг бараа үйлчилгээний зардлыг өглөг, 41.0 хувийг байгууллагад төлөх өглөг эзэлж байна.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 0.6 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 23.1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сан 11.7 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан 4.9 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 10.2 сая төгрөгийн татвар ногдуулж, 9.5 сая төгрөгийг шилжүүлж, 0.7 сая төгрөгийн татварыг дутуу төлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8217.2 сая, эцсийн үлдэгдэл 8299.6 сая төгрөг болж, 82.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1903.0	1903.0	0	22.9
Хуримтлагдсан үр дүн	2555.2	2639.0	83.8	31.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3759.0	3757.7	1.3	45.3
Дүн	8217.2	8299.7	85.1	100.0

Эх сурвалж: Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8299.7 сая төгрөг болж 85.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс оны эцэст 3757.7 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн актлагдсан хөрөнгөтэй холбоотой гарсан өөрчлөлт байна. Хуримтлагдсан үр дүн 2639.0 сая төгрөг болж 83.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10. Орлогын данс

Алтай сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 243.7 сая төгрөгийн орлого оруулж, бусад орлого 11.5 сая төгрөгийн, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 2675.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 718.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 71.1 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 125.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 75.5 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 287.7 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч нийтдээ 4209.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4209.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 153.1 сая төгрөгөөр буюу 1.04 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

3.5.11 Зардлын данс

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3956.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 303.4 сая төгрөгөөр буюу 7.7 хувиар өссөн байна.

Нийт зардлын 98.2 хувь нь бараа үйлчилгээний зардал, 1.8 хувь нь урсгал шилжүүлэг байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 2.7-195.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зардлын данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан, 1-12 дугаар сарын 1,458.0 сая төгрөгийн цалингийн цэсийг аудитад ирүүлээгүй тул цалингийн зардлыг тулган шалгах боломжгүй, үдийн цай, үдийн хоолны зардалд 30.3 сая төгрөгийн төөс зарцуулж, оны эцэст 7.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч санхүүгийн программд бөөн дүнгээр орлогод авч, зарлага гаргасан, тээвэр шатахууны зардалд 1.2 сая төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй, гэрэл цахилгааны зардлын батлагдсан төсвөөс 3.3 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр аж ахуйн материалын зардалд зарцуулсан, жижиг мөнгөн сангаар 6.5 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал, үйлдвэрчний эвлэлийн татварт 22.7 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

2. Хүүхдийн цэцэрлэг оны эцэст 25.3 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарч хүнсний материалыг бодит хэрэгцээнээс их хэмжээгээр нөөцөлсөн нь чанар байдал алдаж муудах, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй тул албан шаардлага хүргүүлсэн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3702.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3549.5 сая төгрөгийг урсгал зардалд, 152.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2675.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 757.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 162.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 32.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 73.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 3686.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 2667.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 755.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 32.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 163.0 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 68.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 68.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүний 68.5 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 10.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 5.2 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2665.6 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Алтай сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 154.1 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор Алтай сумын төсвийн орлогыг 154.1 сая төгрөгөөр баталж өөрчлөлт оруулаагүй байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 154.2 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 255.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 101.1 сая төгрөгөөр буюу 165.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	152.6	241.8	89.2	95.4
II.Татварын бус орлого	1.5	11.7	10.2	4.6
Нийт дүн	154.1	253.5	99.4	100.0

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хүн амын орлогын албан татвар бууны албан татвар 0.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.1 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлого төлөвлөгөөний давж биелэгдэхэд улсын тэмдэгтийн хураамж 24.3 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 67.0 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 56.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 255.4 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 101.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	61.1	61.1	
2	Сумын ЗДТГ	387.2	385.2	2.0
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1739.1	1735.1	4.0
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	215,7	215,7	
5	Хүүхдийн цэцэрлэг	454.9	450.4	4.5
6	Соёлын төв	78.5	78.5	
7	Эрүүл мэндийн төв	529.5	529.5	
8	ОНХСан	162.9	152.5	10.4
9	СХС	73.7	68.5	5.2
	Нийт дүн	3702.7	3676.5	17.6

Аудитын илрүүлэлт:

1. Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн ЗДТГ 7.5 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 1.7 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 3.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй тул тус тус албан шаардлага хүргүүлсэн.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтай сумын төсөвт байгууллагууд дээд шатны төсвийн захирагчаас 115.2 сая төгрөгийн, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 9.0 сая төгрөгийн, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1.7 сая төгрөгийн нийт 125.9 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 30.5 сая, хангамж бараа материалын зардалд 13.8 сая, нормативт зардалд 21.0 сая, эд хогшил урсгал засварын зардалд 3.5 сая, томилолтын зардалд 1.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 15.0 сая, урсгал шилжүүлэгт 30.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Засаг дарга нь 2021 онд нийт 3702.0 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3702.0 сая 76 мэдээллийг хугацаанд ил тод байршуулж, 3 мэдээллийг хоцроосон байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 6 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Сумын ТТЗ-ийн багцад хамаарах Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 630.4 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 529.2 сая төгрөгийн 103 мэдээллийг хугацаандаа байршуулж, 14 мэдээллийг хугацаа хоцроосон тул зөвлөмж, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль оруулбал зохих 149 мэдээллээс 41 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан тул албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт: №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж							
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2125.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс сумын төсөвт байгууллагын дүнгээр 20.6 сая төгрөгийн 3 залруулга хийгдэж, 6.2 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 2098.9 сая төгрөгийн 7 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын ЗДТГ	2	57.8					2	57.8		
2	Алтай сумын Соёлын төв	1	68.1					1	68.1		
3	Алтай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	6	1986.9	3	20.6	1	1.4	2	1964.9		
4	Алтай сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	1	0.7			1	0.7				
5	Хүүхдийн цэцэрлэг	1	3.9					1	3.9		
6	Алтай сумын Эрүүл мэндийн төв	3	8.3			1	4.1	1	4.2	1	
Нийт дүн		14	2125.7	3	20.6	3	6.2	7	2098.9	1	

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидал тусгах алдаа зөрчил гараагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын ТТЗСНТайлан										